

МОНГОЛЫН БАРУУН БҮС НУТАГ ДАХЬ БАПТИСТ ШАШНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ НЬ

Ц.Пүрэвсүрэн (Ph.D)
НХУС. Хөвд их сургууль

Түлхүүр уг: Христосын шашин, протестант, шинэ шашны хөдөлгөөн, аугсбургийн шүтлэг, баптизм, усан баталгаа.

Төвч утга: Энэхүү өгүүлэлд Монголын баруун бүс нутгийн хүрээнд Баптист шашин хэрхэн оршин тогтнож, түүнийг түгээн дэлгэрүүлж буй асуудлыг тодруулан үзэхийг хичээсэн болно. Ингэхдээ уг шашны үүссэн түүхийн асуудал, бүс нутагт хэрхэн дэлгэрсэн хийгээд шашны номлол, зохион байгуулалт, өнөөгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

* * * * *

1990-ээд оноос Монголд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр нөлөөгөөр хаалттай нийгмээс нээлттэй нийгэмд шилжиж эрх зүй, улс төр, эдийн засаг, соёлын орчинд өөрчлөлт явагдсан нь шинэ нөхцөл байдлыг бий болгосон. Өнөөдөр манай улсад уламжлалт буддын шашны зэрэгцээ өөр бусад олон шашны нөлөө нэвтэрч байгаа, тус тусын шашныг эрхэмлэгч нийгмийн бүлгүүдийн ялгарал явагдах болсон, тэдний эрх ашгийг илэрхийлэгч шашны болон шашин-олон нийтийн, шашин-улс төрийн шинжтэй, шашин-боловсролын байгууллагууд үүсч байгаа зэрэг нь **нэгдүгээрт**, шашны судалгааг зөвхөн буддын шашнаар хязгаарлах бус, өөр бусад шашинд хандах; **хоёрдугаарт**, сүсэг бишрэлийн илрэх гадаад хэлбэрүүдийг бүртгэн тоочих байдлаар судалгааг хязгаарлах бус, түүний цаадах “утга санаа”, сэдэл шалтгаан, үзэл номлолын агуулгыг нээх, улмаар түүний статик, динамик зүй тогтлыг илрүүлэх чиглэлд судалгааг өргөжүүлэх; **гуравдугаарт**, асуудалд зөвхөн нэг л өнцгөөс, нэг аргазүйгээр хандах бус, өөр өөр талаас нь, олон янзын аргазүйн үүднээс хандах, харьцуулан шинжлэх; **дөрөөдүгээрт**, төр сүм хийдийн харилцааны асуудал, хууль эрх зүйн орчны нөхцөл, гадаад ба дотоод орчны харилцан нөлөөллийг судлах; **таевдугаарт**, монгол улсын үндэсний аюулгүй байдал, гадаад харилцаа, геополитикийн асуудал зэрэг олон шинэ нөхцөл байдал байна. Мөн монголын нийгмийн давхраажилт, хувьсал, өөрчлөлтийн асуудалтай нягт уялдуулан цогц судалгаа хийх зайлшгүй шаардлага буйг цаашид анхаарвал зохилтой. Энэ бүхэн нь шашны асуудлыг шашин судлалд шинэ хандлага, шинэ аргазүйгээр судлах шаардлага буйг илтгэх болсон. Социологийн сонгодог төлөөлөгчид Карл Маркс, Э.Дюркхейм, М.Вебер, Т.Парсонс нарын эрдэмтэд тодорхой шинжлэх ухааны хөгжил, техник, технологийн дэвшил нь секуляризаци /иргэншихүй/-г бий болгож шашны үзэл ухамсарын байр суурь буурна гэж үзсэн байдаг. Гэвч 1990-ээд оноос

манайд яг эсрэгээрээ явагдах болсон нь даяаршил /глобализации/-тай салшгүй холбоотой юм. Манай оронд шашнаар халхавчилсан эдийн засаг, боловсрол, улс төр, соёл, олон нийт, боловсролын маш олон байгууллага, бүлэглэл, нийгэмлэг, сүлжээ өнөөдөр монгол орныг аалзны тор мэт хэрж буйд холбогдох газар нь анхаарах цаг нэгэнт болсон байна. Энэ удаа бид протестант шашнаас улбаатай “шинэ шашны хөдөлгөөн”-ий нэгэн чиглэл болох баптист шашны талаар авч үзэх болно. Судлаач С.Цэдэндамба¹, Ц.Пүрэвсүрэн² С.Дэмбэрэл³, Ж.Алтайбаатар⁴ нарын судлаачид Монгол дахь “шинэ шашны хөдөлгөөн”-ий талаар судлан авч үзсэний дээр эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллүүд хэвлүүлсэн байна.

Дэлхийн томоохон шашны нэг нь МЭИ зуунд үүссэн христосын шашин юм. Энэ шашинд 1054 оны орчим үзэл номлолын хагарал гарч зүүн ортодокс /үнэн алдартан/ ба баруун /католик/ гэж салсан. Улмаар XVI зууны үед католик шашнаас протестантууд бий болсноор олон жижиг урсгалуудын эхлэл тавигдсан гэж үздэг. Түүхийн эх сурвалжаас үзвэл, дундад зууны турш Европын ихэнх оронд хязгааргүй ноёрхож байсан католик сүм хийдийн хэрээс хэтэрсэн үйл ажиллагаа, эд баялагийн хуримтлал, санваартнуудын хуурамч сүсэг, ёс суртахуунгүй байдал олны дургүйцлийг төрүүлэх болсон. Ялангуяа, католик шашны сүм хийдийн орлогын нэг үүсвэр болох “индульгенц” хэмээх нүглийн “өршөөл” худалдах практик нь хэрээс хэтэрсэн байна. 1517 онд индульгенцын эсрэг сүмийн хамба лам Мартин Лютер (1483-1546) эсэргүүцлээ илэрхийлснээр протестант шашны түүх гараагаа эхэлсэн гэж үздэг.

Протестант шашны түүхийг судлаачид тухайлбал, Г.Шверхофф 1521 онд Ф.Меланхтоны боловсруулсан “Аугсбургийн шүтлэг” хэмээх бичиг баримт гарснаар энэ шашин албан ёсны шашин болсон түүхтэй гэж үзээд “1555 онд улс төрийн эрх мэдэл болон жинхэнэ шашны төлөөх тэмцэлд протестантууд ялагдах даваанд хүрэхэд Аугсбургийн шашны энхийн гэрээ байгуулагдан шашны хоёр урсгалыг түр зуур хүлээн зөвшөөрсөн”⁵ хэмээжээ. Мөн О.Чимэг “Протестант шашин нь XV зууны Европт реформаци буюу шинэчлэл хэмээх нэрээр түүхэнд орсон нийгмийн болон оюун санааны хөдөлгөөний үр дүнд христос шашны гурав дахь том урсгал болж үүсчээ”⁶ гэж тэмдэглэсэн байна. Энэ бүхнээс үзэхэд өрнө дахинд XV-XVI зууны сэргэн мандалтын оюун санааны тэсрэлтийн үр дүн болж протестант шашин үүссэн нь сэтгэлгээний олон ургальч хандлага төлөвшиг

¹ С.Цэдэндамба “Монгол дахь шашны нөхцөл байдал” (XIX-XX зууны зааг үе) УБ.,2003; С.Цэдэндамба, “Уламжлалт ба уламжлалт бус шашны харилцааны асуудал” / Төр сүм хийдийн харилцаа: орчин үе. УБ.,1998

² Ц.Пүрэвсүрэн “Монголын баруун бус нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд” / Философи, шашин судлал. №308 (51). УБ.,2009. тал.154-164.

³ С.Дэмбэрэл Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүддээ нөлөөлөх арга, түүнээс сэргэжлэх нь //Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.104-113.

⁴ Х.Алтайбаатар Шинэ шашны хөдөлгөөнийг судлах арга зүйн хоёр хандлагын тухайд // Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.134-144.

⁵ Г.Шверхофф. Реформацийн түүхийн шинэхэн судалгаанууд. Дундад зууны шашны түүхэнд холбогдох эх сурвалжуудын дээж бичиг. УБ., 2008. 161 дэх тал

⁶ О. Чимэг. Протестант шашин. Философи, шашин судлал. УБ., 2009. №318 /55/ 93 дахь тал

үндсийг бүрдүүлсэн гэж үзвэл зохилтой болно. Мөн энэ үеэс христосын шашин католик, үнэн алдартны, протестант гэсэн гол гурван чиглэлд хуваагдаж эхэлсэн байна.

Энэхүү протестант шашнаас салбарлан гарсан орчин үеийн гэж хэлж болохуйц шашны урсгалуудыг судлаачид “шинэ шашны хөдөлгөөн” хэмээн нэрийдэх болсон. “Шинэ шашны хөдөлгөөн”-үүд дотроос монголд дэлгэрч буй шашны нөлөө бүхий чиглэл нь баптист шашин юм. XVII зууны үеэс баптистууд анх Англид бий болсон бөгөөд анхны номлогч нь Жон Смит (1554-1612) гэж үздэг. Баптист шашин нь XVII зуунд Англид үүсэж, улмаар Герман, Нидерланд, Ирланд, Америк, Орос зэрэг улсуудад түгэн дэлгэрсэн. Тухайлбал, 1636 онд Рожер Ульеимс гэгч индианчуудын газар нутгийг колончилох болж 1639 онд 10 хүнтэй баптист бүлэглэл байгуулсан. Улмаар 1707 оноос Нью-Жерси, Пенсильвани, Феладельфи зэрэг хотуудаар номлогчид сургаалиа түгээж сүм барьж эхэлсэн. Орост XIX зууны сүүл үеэр баптист шашныг англичууд түгээн дэлгэрүүлсэн. 1992 онд евро-азийн евангалийн баптист холбоо байгуулагдсан төдийгүй ОХУ, хуучин ЗХУ-ын ТҮХН-ийн орнуудаар маш хүчтэй тархсан. Харин Зүүн Өмнөд Азийн улс орнуудад Америкаас уг шашныг түгээн дэлгэрүүлсэн нь манай оронд нэвтэрч ирсэн байна. Баптист чиглэл нь “шинэ шашны хөдөлгөөн”-үүд дотроо хамгийн хурдтай түгэж, хүрээгээ тэлж буй шашны нэгэнд ордог байна. Монголд буй христосын уламжлал бүхий аль ч шашны чиглэлүүд шашин суртачилах үйл ажиллагааныхаа хүрээнд ямагт нэг нь нөгөөгөө үгүйсгэж байдаг онцлогтой. Монголын Эвангелийн эвсэл “Бид нэг эзэн, итгэл, нэг сүнсний эв нэгдлийг эрхэмлэнэ” уриан дор бүх сүм чуулганыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана. Тэд улирал сар бүрт томоохон цугларалт, үйл ажиллагаа зохион байгуулна. Жишээлбэл, Улаанбаатарын сүм чуулганууд “хайрын гэгээ” соёлын төвд /нэгдүгээр цуглаан/, орон нутгийн сүм чуулганууд тухайн өдөр, байгаа газраа хамтдаа “Монголын залбирлын хөдөлгөөн” өөрчлөлтийн төлөө нэгдэн залбирцгаая, магтаал залбирлаар улс үндэстнийхээ төлөө нэгдэцгээ! уриан дор 2018 оны 05 сарын 11-12-нд цугларалт, сургалт семинар зохион байгуулсан байна. Баптист сүмүүд одоо байр сууц, хөрөнгө, мөнгөний хувьд бэхжсэн, манай улсын иргэд сүмд голлох байр суурь эзлэх болсон, монгол орны талаар өөрсдийн маш сайн судалгаатай, төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Баптистууд анх хувь хүний шашны эрх чөлөө, аливаа шашин шүтлэгт хүлээцтэй хандах, төр сүм хийдийг тусгаарлах, нийгмийн бүх гишүүдэд баптист шашин шүтэх, номлох эрх олгохыг шаардаж байсан. Баптист шашны сургаал нь 1905 онд Баптистуудын их хурлаар баталсан “Үндсэн долоон зарчмууд” дээр үндэслэдэг байна. Үүнд⁷:

1. Ариун Бичээс нь итгэл болон практик амьдралын цорын ганц эрх мэдэл байх;
2. Сүм зөвхөн “итгэлээр” баптисм хүртсэн хүмүүсээс бүрдэх ёстой (баптизм өөрөө хүний тааллын дагуу хийгддэг бөгөөд тэр үүнийг хүлээн авахад бэлэн гэдгээ мэдэрсэн үед л хийдэг);
3. Сүмийн бүх гишүүд нийтээрээ санваартан

⁷ https://bigenc.ru/religious_studies/text/ Баптизм-Большая российская энциклопедия –электронная версия. Ишлэсэн 2019.04.10.

төдийгүй тэгш эрхтэй байх; 4. Төрөөс тусгаарлагдсан, түүнээс хараат бус байх. Баптист сүмүүд ихэвчлэн сард нэг удаа (1 дэх ням гарагт) сүмийн цуглаан зохион байгуулдаг байх; 5. Баптист ба Баптизмтай харилцах нь дээд тусгай ариун ёспол биш, харин хүндэтгэл, шашны үйл хэрэг юм. Баптист шүтлэг бишрэл нь билэгдэл бус, үйл хэрэг, үйлдэл байх; 6. Залбирлын цуглаан дээр Ариун Судрыг номлох, уншихад гол анхаарлаа хандуулдаг байх; 7. Уламжлал. Баптист цуглааны сүм, залбирал хийх өрөө тэнхим маш энгийн байх; Тэнхим нь сайн мэдээг номлох, унших, тайлбарлах сургалтын орчин байдаг. Харин цаг хугацааны явцад өөрчлөгджэх орчин үед мөргөл, залбирлийн тэнхимд тахилын ширээ, ханын зураг, зарим гоёл чимэглэлийг харж болно.

Юуны өмнө Баптизм гэдэг нь гэгээн нууц ёс бөгөөд түүгээр дамжин сүмийн хууль ёсны гишүүн болдог⁸. Энэ нууц үйлийн үед итгэгч хүн өвлөсөн буюу хувийн нүглээс ангижирч дөнгөж төрсөн хүүхэд адилаар христосын сүмийн гишүүн болдог байна. Өөрөөр хэлбэл, бурханы авралд багтаж шинээр төрж, ертөнцийн эзний хүүхэд болох төдийгүй сүм хийдийн эгнээнд орж буйгаа илэрхийлсэн үйлдэл юм.

Баптизм хүртэх гэгээн нууц үйлээр дамжуулан христос шашинтан болохын тулд бурхны дөнгөж төрсөн хүүхдийн адил хишигийг хүртдэгт учир нь байгаа юм. Зөвхөн үүний дараа л тэдний оюун санааны амьдралыг өсөн нэмэгдүүлэхийн тулд бусад бүх нууц үйлд оролцуулахыг зөвшөөрнө. Баптизм хүртэх нууц үйл хүнд нэг л удаа үйлдэгдэх ба дахин хэзээ ч давтагдахгүй. Хүн биеэрээ нэг л удаа төрдөг. Иймээс оюун санаа нэг л удаа төрж болно гэж үздэг. Баптизмын хамгийн чухал нь гэгээн гурвал: эцэг, хүү, гэгээн сүнсний нэрээр номлогчийн /пастер/ тусгай залбирлаар гурвантаа ус руу орох явдал юм. Ус руу гурвантаа орох нь гэгээн гурвалын эсрэг үйлдсэн нүглийг устгаж байна гэсэн утгатай. Харин уснаас гурвантаа гарч ирэх нь бурхны амьдрал руу дахин төрж буйг бэлэгддэг. Усаар баптизм хүртэх нь ер бусын ариусалыг⁵ бэлэгдэж байдаг. Энэ тухай шинэ гэрээнд “... Иймээс явж, бүх үндэстнүүдийг дагалдагч болгогтун. Эцэг, хүү, ариун сүнсний нэрээр тэдэнд баптизм хүртээж ... ”⁹ гэж туссан байдаг. Дашрамд өгүүлэхэд, орчин үеийн ялангуяа протестант шашны зарим чиглэлд “Эзэн тэнгэрээ нууцлаг хүчин”¹⁰ мэтээр тайлбарлах явдал байдаг.

“Шинэ шашны хөдөлгөөн”-ийнхөн тэр дундаа Баптист шашинд миссонерүүдийн /элч болох явдал/ үйл ажиллагаа өөрөөр хэлбэл, шашнаа дэлгэрүүлэх үйл ажиллагаа маш идэвхитэй явагддаг. Баруун бүс нутагт Баптист шашныг солонгосчууд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн. Ховд их сургуульд Компьютер–солонгос хэлний бакалаврын сургалтыг 2007-2008 онд БНСУ-ын дэмжлэгээр байгуулсан. Нийт 60 орчим оюутан төгссөн. Энэ бакалаврын сургалтын багш нь солонгос хүн байсан агаад тэрбээр баптист шашныг суралцагч оюутан нарын дунд сурталчилж тэдний ихэнхи нь баптист шашны итгэгч, пастер болсон. Одоо тэд Улаанбаатар болон бусад газруудад баптист шашныг суртачилах, түгээн дэлгэрүүлэх үйл хийж байна. Баптист сүм нь

⁸ Дорны үнэн алдартны шашины сүмийн сургаал агуулга. УБ., 2011. 48 дахь тал

⁹ Шинэ гэрээ. Матай. 28.18

аймгийн төвд хоёр давхар сүмийн байртай, унаа машин, санхүүгийн тухайд нэлээн хүчирхэг. Сүмийн нэр “Ховд-Амьд Үг Баптист сүм”. Солонгос улсаас ирсэн номлогч билээс үг заана.

Ховдод 2006 онд анх үйл ажиллагаагаа түгээж эхэлсэн, 300 гаруй ахан дүүстэй /итгэгчтэй/ байсан бол одоо энэ тоо 2-3 дахин өсөн нэмэгдсэн. Баруун бусийн Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймаг болон томоохон хүн ам олондой сумдад салбартай. Баруун бусийн төв нь Ховд аймаг. Баян-Өлгийд баптист сүм байхгүй. Учир нь казахууд амьдрах учир ислам шашин зонхилен. Эмэгтэй чаминним, эрэгтэй күнжүнэм мин гэж нэрлэнэ. Хамрах хүрээ нь өндөр настай эмээ нар, хүүхэд залуучууд (ХИС-ийн оюутнууд, Ховд-Хөгжил Политехник коллеж), зарим дунд сургуулийн багш нар, тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс байдаг. Оюутан итгэгчдийг хашаа байшин, гэр худалдаж авч өгөөд хамт буюу ахан дүүсээр нь амьдруулна. Сар бүр 2-3 удаа Библийн семинар явагдана. Ойролцоогоор сард 4 долоо хоног байдаг гэж тооцвол ням, лхагва гаригийн цуглаан нийлээд 8 удаа, сар бүрийн 2-3 семинарыг нэмбэл нийт 10-12 удаа сүмд очиж сургалт, семинар, цуглаанд очдог байна. Энэ цуглаанд хүн тус бүр нэгээс цөөнгүй хүн /1 итгэгч 2 хүн/ дагуулж очих үүрэгтэй. Зорилго биелэхгүй бол хүн төрөлхтөн аврагдахгүй тул хичээж ажиллах хэрэгтэй. Есүс Христ удахгүй энэ ертөнцөд эргэж ирэх тул бүх хүмүүс итгэгч болж аврагдсан байх ёстой.

Баптистууд нь шашны түгээн дэлгэрүүлэх, шашны номлол сургаалыг сурчилах үйл ажиллагаандaa

- Нийгэмлэг байгуулах
- Номлогчдыг тогтмол ажиллуулах
- Хувь хүнийг ухуулах
- Сайн мэдээ дуулгагч нарыг ажиллуулах
- Цуглаан зохион байгуулах
- Хүүхдийн тусгай дугуйланг зохион байгуулах
- Хамт олны урилга
- Нийтийн баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд гэх мэт аргуудыг өргөн хэрэглэдэг байна.

Эдгээрийг товч дурдвал;

1. Нийгэмлэг байгуулах. Нийгэмлэг байгуулан түүнийг зөвлөл тэргүүлдэг бөгөөд түүнд туршлагатай номлогч орох ба нийгэмлэгт хэд хэдэн хороо ажиллана¹¹. Үүнд, Баптист шашны ерөнхий төв нийслэлд төвлөрнө, салбар зөвлөл бүс нутгийн төвд (хангайн бүс, төвийн бүс, зүүн бүс, баруун бүс, Улаанбаатарын бүс) хороо нь аймгуудад, хөтөлбөрийн хороо сумдад гэх мэт зохион байгуулалтаар ажиллана. Хөтөлбөрийн хороо нь мөргөлийн цуглааныг илүү сонирхолтой болгох зорилгоор тусгай хөтөлбөр боловсруулдаг байна. Бүх мөргөл цуглааныг ёслол төгөлдөр, дуутай хөгжимтэй явуулж, заримдаа үнэгүй өдрийн цай, хоолонд оруулдаг. Цуглаан бүр дээр дуулдаг найрал дуунд их анхаарахын зэрэгцээ нийгэмлэгүүдэд төгөлдөр хуур, чавхдаст болон үлээвэр хөгжим байдаг. Найрал дууг цуглааны эхлэл ба төгсгөлд бүгдээрээ босож зогсоод дуулах ба энэ нт олон түмний сонирхлыг маш их татдаг.

¹¹ Хувийн архив

2. Номлогчдыг байнга ажиллуулах. Номлогчид Библийн сургаалийг амьдралын жишээгээр баталгаажуулахыг эрмэлзэж, номполдоо сонгодог зохиолч, нэр алдартай хүмүүсийн амьдралаас ишлэл татаж, сонсогчдын сэтгэлийг хөдөлгөхийн тулд уянгын халилыг их ашиглана¹². ЕБС-ийн багш нар баптист шашны итгэгч болсон тохиолдолд тэд хичээл сургалтын цагийг ч уг шашны сургаалийн номлох сурталчилах үйл явуулдаг. Эс бол их, дээд сургууль, коллеж, сургууль соёл, олон нийт бөөнөөр цугларсан газарт шашин сурталчилах үйл хэргийг маш идэвхитэй явуулна. Мөн хөдөө орон нутгаас төвд шилжиж ирсэн малчин, тариаланч г.м. эдийн засаг, соёлын хямралд орж буй айл өрх иргэдэд шашныг сурталчилна. Номполын утга, хамгийн их хөндөгдөх сэдэв нь удахгүй ертөнцийн төгсгөл ирэх тухай гутранги үзэл. Тухайлбал, хүн төрөлхтөний үйлдсэн нүгэл маш их “тэднийг шийтгэж, хүмүүжүүлэх нь бурхны хамгийн чухал, үр дүнтэй хэрэгслүүдийн нэг” гэж үзэх бөгөөд түүнд тулгуурлан баптистуудын номполын үйл ажиллагаа үндэслэгдэж байна. Жишээ нь “Бүгд манайд элсэж баптист болоорой. Удахгүй Есүс христ энэ ертөнцөд шүүлт явуулна. Баптистын эгнээнд элсээгүй хүн бүр тамд, харин итгэсэн нь аврагдах болно. Тиймээс эргэн тойрондоо байгаа хайртай хүмүүсээ баптист болгох шаардлагатай хэмээн номлоно. “Төвөөс” номлогчдыг байнга урьж авчирах ба тэднийг ирэхэд нь өргөн сурталчилж, бүсийн чуулган зохион байгуулна. Бүсийн чуулганыг аймгийн төвд зохион байгуулна. Энэ үеэр баптист сургуулийн дадлагажигч нар сайн мэдээ дуулгагч болж ирэх бөгөөд тэднийг сүр дуулиантай утаж, олон нийтийн анхааралд өртуулэх сурталчилгаа явуулна.

3. Хувь хүнийг ухуулах. Цуглаанд анх удаа ирсэн хүнд тусгай сургагч томилж, тэр нь нийгэмлэгийн үйл ажиллагаа, шашны сургаалын үндэс зэрэгтэй холбоотой асуултанд хариулж, цуглаанд дахин ирэхийг урьдаг байна. Хэрвээ уг хүн ахин дахин цуглаанд ирвэл нийгэмлэгийн зөвлөлөөс түүнд “харгалзагчийг” томилдог байсан ба тэрээр гэрт нь очиж, ёс суртахууныг нь хянаж, сургаалыг тайлбарлаж, зааж сургаснаар загалмайлахад бэлтгэнэ. Хүн бүхэн Баптист сүмд явж библийн семинарт сууснаар зайлшгүй аврагдана. Итгэгч аврагдсаны дараа сахих 5 зүйл байна.Үүнд: Нөхөрлөл, уг, магтан дуу (монгол хэл дээр), үйлчлэл (сүмдээ үйлчлэх тухайн итгэгчид урилга тараах, сүмд явахыг ухуулах, дотоод ажил г.м.,) залбирал. Библээс гадна солонгос хэл, төгөлдөр хуур заана.

Аврагдсанаар сүмд байнга явдаг итгэгч болдог. Итгэгч нь библийн семинарт сууж дууссаны дараа гэрчлэлээ ярина. Аврагдсан энэ өдрийг тухайн хүний төрсөн өдөр гэж үзнэ. Учир нь хүн угаасаа нүгэлт амьтан бөгөөд Есүс Христийн сургаалийг дагаж, үнэнч итгэгч болсноор буянт хүн болно.Төрсөн өдрийг сүмийн зүгээс гурав, гурван сараар нь нэг багцлан Тухайлбал, 1, 3, 4 гэх мэт саруудад аврагдсан хүмүүсийн төрсөн өдрийг тэмдэглэнэ. Төрсөн өдрөөр нь пастер /номлогч/ уг хэлж бусад хүмүүс хүндэтгэлтэйгээр өнгөрүүлнэ. Ингэснээрээ итгэгчид бүгд Есүс Христийн хүү, охин болох учир нэгэн ахан дүүс, аав, ээжүүд, ах, эгч нар болдог. Итгэгчид хоорондоо гэр бүл болох нь чухал. Итгэгч биш хүнтэй гэрлэсэн тохиолдолд гэр бүлийн хүнээ авч ирж баптист хүртээж аврах ёстой. Итгэгчид хоорондоо

¹² Хувийн архив

толгойгоо тонгойлгож, солонгосчууд шиг хүндэтгэлтэйгээр мэндэлдэг. 6666666

4. Шашны сургаалыг түгээн дэлгэрүүлэх хамгийн үр дүнтэй аргуудын нэг нь сайн мэдээ дуулгагч нарыг ажиллуулах явдал юм. “Улаанбаатараас аймгуудад” хүртэл бүх монгол орныг засаг захиргааны нэгжийн хувиарлалтаар хувааж тус бүрд сайн мэдээ дуулгагчийг томилж тэдгээр нь бүтэн жил ажиллана. Ингэж зохион байгуулснаар нийгэмлэгийн гишүүдийн тоог ихээхэн өсгөх боломжтой болдог. Зөвлөлүүд нь сэтгүүл, библи, шашны дуу, хуанли зэргийг хэвлэж, нийгэмлэгүүдэд орон тооны цалинтай номлогчдыг ажиллуулж байна. Ойролцоогоор сард 4 долоо хоног байдаг гэж тооцвол ням, лхагва гаригийн цуглаан нийлээд 8 удаа, сар бүрийн 2-3 семинарыг нэмбэл нийт 10-12 удаа сүмд очиж сургалт, семинар, цуглаанд очдог байна. Энэ цуглаанд хүн тус бүр нэгээс цөөнгүй хүн дагуулж очих үүрэгтэй. Зорилго биелэхгүй бол хүн төрөлхтөн аврагдахгүй тул хичээж ажиллах хэрэгтэй. Есүс Христ удахгүй энэ ертөнцөд эргэж ирэх тул бүх хүмүүс итгэгч болж аврагдсан байх ёстой.

Тэдгээр нь шашиндаа хэт автсан, маш идэвхтэй, лам нарыг бодвол ёс суртахууны тал дээр нэн тогтвортой байдаг. Иймээс тэдний сүсэгтний тоо байнга нэмэгдэх хандлагатай байна.

5. Шашны удирдагчид нь залуучууд, өсвөр үеийнхэнтэй ажиллах шаардлагатайг онцолдог. Зохион байгуулалтын хувьд залуучуудын нөхөрлөл нь дотроо хайр, энэрэл, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд гэж 4 хуваагдана. Дотоод бүрэлдэхүүний хувьд пастер буюу солонгос номлогч, орчуулагч, менежер, залуучуудын багийн ахлагч, аавуудын нөхөрлөл, ээжүүдийн нөхөрлөл, итгэгчид гэж байна. Есүс Христийн 10 сургаалийг бүх итгэгчид байнга санаж, сахих ёстой. Үүнд:

1. Чи надаас өөр бурхантай байж болохгүй
2. Чи өөртөө зориулж шүтээн бий хий, Чи тэдэнд мөргөж үйлчилж болохгүй
3. Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтуун.
4. Чи өөртөө бурхан эзний нэрийг дэмий бүү дурд
5. Эцэг эхээ хүндэл
6. Чи хүн бүү ал
7. Чи бүү завхайр
8. Чи бүү хулгайл
9. Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил
10. Чи хөршийнхөө гэр оронд бүү шунахайр

Бусад шашны урсгалыг үл хүлээн зөвшөөрнө. Тухайлбал, буддын шашин болон мормоны урсгалыг эрс эсэргүүцдэг. Есүс Христийн бусад урсгал нэн ялангуяа мормончуудыг библийн сургаалыг гүйвуулагчид хэмээн үзнэ.

Сүм, хийдийн үйл ажиллагаанд хамрагдаж буй хүмүүс 10-ны 1-ын өргөл гэж өргөдөг ба олсон орлогынхoo 10 хувийг сүмдээ өргөл болгон өгдөг байна. Хүн бүр сард олсон орлогынхoo 10-ны 1-ийг заавал сүмд өгөх ёстой. Бидэнтэй ярилцсан нэгэн охин ...би хамгийн ихдээ 10000, 5000, 1000 төгрөг өгч байсан өнгөрсөн сард 50 төгрөг өгсөн гэж хариулсан байсан... хэрвээ хүүхэд өөрийн олж буй орлогынхoo 1 хувийг сүмдээ өргөл болгон өгөх ёстой юм бол сар бүр авч буй хүүхдийнхээ мөнгөнийхөө хувийг ч өгөх ёстой болж байна. Сүмийн гишүүн бүр 10-ны 1-ийн өргөл зайлшгүй өгөх ёстой бөгөөд зарим үед сүмд тодорхой хөлс

мөнгөөр хэмжигдэх ажил үйлчилгээ гүйцэтгэж түүнийгээ өргөлд тооцуулж болно.

Санхүүгийн хувьд солонгосын Ансон сүмийн ахан дүүсээс илгээсэн мөнгө, итгэгчдийн өргөл хандив, худалдааны орлогоос (солонгосын комиссын барааны дэлгүүр) санхүүжнэ. Дэлгүүрийн комиссын бараанаас амьдрал ядуу хүмүүст тарааж өгнө.

6. Дугуйлан явуулахдаа гишүүдийн насыг харгалзан үзэж төрөл бүрийн ажил зохион байгуулахын зэрэгцээ хүүхдийн тусгай дугуйланг зохион байгуулна. Хүүхдүүдэд тоглоомын хэлбэрээр бурханы сургаалыг тайлбарлаж, Библийн текстийг нэг бүрчлэн үзэж, төрөл бүрийн сэдвээр яриа өрнүүлж /гэрчлэл/ тэдэнд зориулж хүүхдийн баяр зохион байгуулан, амттан тарааж, шашны агуулгатай зурагнууд, бэлэг өгч тараана. Мөн аялал зохион байгуулна. Баяр болон аяллын үеэр бүх хүүхдүүдийг бүр баптист биш байсан ч хамаагүй урьж оролцуулна. Хэдийгээр энэ бүхнийг хуулиар хориглосон боловч тэд үйл ажиллагаагаа идэвхитэй явуулсаар байна. Тухайлбал, баптистууд зохион байгуулдаг зул сарын баяр, халлион баяр нь хүүхдүүдийн дунд хамгийн нэр хүндтэй нь юм. Өсвөр үеийнхний дугуйланг секцэд хувааж найрал дууны хамтлаг, хөгжмийн цөөхүүл байгуулж, шашны сэдэвтэй жүжиг тавьж, үдэшлэг зохион байгуулдаг.

7. Залуучуудыг шашинд татан оруулахын тулд жишээ нь, “хамт олны уриалга” гэдэг аргыг ашиглана. Энэ нь дугуйлангийн өргөтгөсөн цуглаан дээр гишүүн бүр нь шашны бус гэр бүлийн болон ажил төрлийн найз нөхдөө урьж авчирах явдал юм. Итгэгч бүр хоёроос доошгүй хүн авч ирэх ёстой. Мөн тусгай ханын сонин гаргаж, тэндээ диваажин болон тамыг дүрсэлдэг бөгөөд тус сонин дээр залуучууд бурханд итгэхгүй бол тамын зовлонг амсана гэсэн утга бүхий ухуулгыг бичиж наана.

8. Нийтийн баяр ёслол, тэмдэглэлт өдрийд тэмдэглэх. Баптист шашинд усан баталгаа буюу баптизм үйлдэх ёслолыг гүйцэтгэнэ. Мөн монголчуудын тэмдэглэдэг баяруудыг бүгдийг нь тодорхой зохион байгуулалттайгаар баптист шашинд итгэгчид, мөн түүнд итгэдэггүй хүмүүсийг ч хамруулан тэмдэглэнэ. Нийтийн баяр ёслолыг тэмдэглэхдээ аль болох олон хүн хамруулахыг хичээхийн зэрэгцээ санхүүжилтийг сүмээс хариуцна. Сүмийн гишүүд буюу аврагдсан хүн өөр шашин шүтлэгтэй эсвэл сүмийн гишүүн бус хүнтэй гэрлэхийг зөвшөөрөхгүй. Тэд бол сатаны хорлолд автсан, муу ёрын сүнсний үргэлжлэл учир сүмд явуулж усан баталгаа хүртээсний дараа л тэдэнд хоорондоо гэрлэх боломж бүрдэнэ. Гэрлэлт бол баптизм хүртсэн ариун хүмүүсийн үйл учир хэн хэнтэй гэрлэхийг сүмийн ахлагч тэдэнд зөвлөж, санал болгоно. Гэрлэх ёслол баптист шашны зан үйлийн дагуу явагдана. Зөвшөөрөхгүй тохиолдолд сүмийн гишүүдээс шахалтад өртөж нэг бол сүмээ эсвэл түүнээс гарч иргэний ёсоор амьдрахд хүргэдэг. Баптистууд дотор сүмийн ахлагчийн саналаар гэрлэсэн хүмүүс нэлээдгүй бий¹³. Сүмийн дотоод дахь хариуцлага хүлээлгэх, дэг журам сахиулах дүрэм, шийтгэл зэрэг нь маш нууцлагдмал бараг гадагш түгэхгүй. Сүмд явж байгаа, явж байсан хүмүүс энэ талаар ярих тун дургүй. Их хатуу дүрэм үйлчилдэг, тэр нь хатуу шийтгэлтэй байдаг гэсэн зүйлийг л ярилцдаг.

¹³ Хувийн архив.

Дүгнэн үзвэл, Монгол улсын хэмжээнд эрх бүхий байгууллагууд шашны асуудлыг цогцоор нь авч үзэх, судлаачдын нэгдсэн санаа бодлыг сонсох, судалгааны ажлын мөрөөр тодорхой үйл ажиллагаа зохион байгуулах, эдгээрийг цэгцлэх шаардлага бий болоод байна. Хэдэн жилийн өмнөх цуглаан өнөөдөр сүм цаашилбал, төрийн бус байгууллага болтлоо өргөжин тэлж санхүүгийн чадавхи, нөлөөллийн хүрээн өсөн нэмэгдэж буйд анхаарах хэрэгтэй байна. Шашны байгууллагууд өнөөдөр нийгмийн бүх чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд, ажилгүйдэл, архидалт г.м. нийгмийн сөрөг үзэгдлүүдийг шийдвэрлэхэд үр нөлөөтэй сайн ажлууд явуулж буй хэдий ч тухайн улсын хуулийг зөрчсөн, хувь хүний эрхийг боогдуулсан г.м. сөрөг үйлдлүүд ч цөөнгүй байна.

Баптист шашин нь “шинэ шашны хөдөлгөөн”-ий нэг чиглэл бөгөөд баптист шашинд сүм хийдийн болон ертөнцийн амьдрал хоёрын хоорондох зааг ялгаа маш бага байдаг. Монголд баптистуудын үйл ажиллагаа нь идэвхижиж улмаар баруун бус нутгийн ард түмний дунд хамгийн нөлөө бүхий шашин болсон нь тэдгээрийн миссонеруудтай шууд холбоотой юм. Тэд /улс төр, эдийн засгийн эгзэгтэй цаг үед/ өөрийн шашнаа дэлгэрүүлэх, сурчилах үйл ажиллагаандaa олон төрлийн аргуудыг хэрэглэж байгаа нь үр дүнгээ өгсөөр байна. Цаашид бид уламжлалт болон уламжлалт бус олон шашны урсгал чиглэлүүдийг Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа явуулахыг шахаж шаардах, тэдний нийгмийн чиг үүрэгт үнэлэлт өгөх, мухар сүсэг, шашны зүй бус үйл үйлдэлээс болгоомжлох зэрэгт анхаарч ажиллах шаардлага байна.

НОМ ЗҮЙ

1. Цэдэндамба С. “Монгол дахь шашны нөхцөл байдал” (XIX-XX зууны зааг үе) УБ.,2003; Цэдэндамба С., “Уламжлалт ба уламжлалт бус шашны харилцааны асуудал” //Төр сүм хийдийн харилцаа: орчин үе. УБ.,1998
2. Пүрэвсүрэн Ц. “Монголын баруун бус нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд” //// Философи, шашин судлал. №308 (51). УБ.,2009. тал.154-164.
3. Дэмбэрэл С. Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүддээ нөлөөлөх арга, түүнээс сэрэмжлэх нь //Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.104-113.
4. Алтайбаатар Х. Шинэ шашны хөдөлгөөнийг судлах арга зүйн хоёр хандлагын тухайд // Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.134-144.
5. Г.Шверхофф. Реформацийн түүхийн шинэхэн судалгаанууд. Дундад зууны шашны түүхэнд холбогдох эх сурвалжуудын дээж бичиг. УБ., 2008. 161 дэх тал
6. О.Чимэг. Протестант шашин. //Философи, шашин судлал. УБ., 2009.№318 тал. 55/ 93 дахь тал
7. Дорны үнэн алдартны шашны сүмийн сургаал агуулга. УБ., 2011. 48 дахь тал
8. Шинэ гэрээ. Матай. 28.18
9. https://bigenc.ru/religious_studies/text/ Баптизм-Большая российская энциклопедия –электронная версия. Ишлэсэн 2019.04.10.

Хавсралт



Ховд аймаг, Баптист сүм. 2019.04.14.



ABSTRACT

Baptism is one of the "new religious movements", and there is a minor difference between churches and the world of existence. As the activities becoming more and more active and considering to be the most influential societies among western region are directly - related to their missionaries. It is proven that it is effective by using a variety of different methods of disseminating and promoting their religion (even in the political and economic crisis times). In the future, we need to pay attention to the flow of traditional and non-traditional religions in order to comply with the Mongolian laws and regulations, to assess their social commitment and to avoid superstition and religious practices.